



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/423

Зуунмод

Зуунмод сумын Соёлын төвийн дэргэдэх
Хүүхдийн дугуйлан байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Зуунмод сумын Соёлын төвийн дэргэдэх Хүүхдийн дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ш.Батмөнх	Соёлын төвийн дарга
Гишүүд:	Ц.Алтанцэцэг	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	А.Нарангэрэл	Номт багийн зохион байгуулагч
	Х.Олзод	Зүүндэлгэр багийн зохион байгуулагч
	Д.Энхтуул	Нацагдорж багийн зохион байгуулагч
	Ч.Анхзаяа	Баруун Зуунмод багийн зохион байгуулагч
	П.Ариунаа	Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн нийгмийн ажилтан
	И.Цэрэнлхагва	Хүмүүн цогцолбор бага сургуулийн нийгмийн ажилтан
	И.Урангоо	5-р сургуулийн нийгмийн ажилтан
	С.Дарьсүрэн	4-р сургуулийн нийгмийн ажилтан
Нарийн бичгийн дарга:	Ц.Оюунтүлхүүр	Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2.Хүүхдийн дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинээр нэмэгдүүлэх ажлыг 2022-2023 оны хичээлийн жилийн I улиралд багтаан зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Ш.Батмөнх), гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Батжаргалд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.САРАНГЭРЭЛ